



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын
гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2, 34.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын дотоодын үнэт цаасны зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй нийт 100,000,000,000 /нэг зуун тэрбум/ төгрөг хүртэл үнийн дүн бүхий өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.
2. Засгийн газрын үнэт цаасны арилжааг зохион байгуулах, үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагаанд “ҮЦТТТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+3 системээр гүйцэтгэх түр журам”-ын 3.1 дэх заалт үйлчлэхгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасны дагуу энэхүү тогтоолын 1-д заасан үнэт цаасны дотоодын үнэт цаасны зах зээл дээр арилжаалагдаж буй үйл явц болон арилжааны тайланг тухай бүр Хороонд ирүүлж, тайлагнаж байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д үүрэг болгосугай.
4. Засгийн газрын үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хийгдмэгц тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг нээж байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, түүнтэй холбоотой төлбөр, тооцоог хийж байхыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.
5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000429